

ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМАН ДАХЬ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ДҮГНЭЛТ

Бор-Өндөр суман дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс хэрэгжүүлж буй “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” нь байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг дэмжсэн, хүний нөөцийн бодлогыг цогц байдлаар хэрэгжүүлэхэд чиглэгдсэн чухал баримт бичиг юм.

Хөтөлбөрийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх, мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах, сургалт хөгжлийн бодлого хэрэгжүүлэх, манлайллыг дэмжих, ажлын байранд тохирсон сонгон шалгаруулалт хийх зэрэг өргөн хүрээтэй зорилтуудыг тусгасан байна. Мөн хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, эрсдэлийг тооцох, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, ил тод байдлыг хангах зэрэг менежментийн чухал үзүүлэлтүүдийг авч үзсэн нь хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх ач холбогдолтой юм.

Хөтөлбөрийн санхүүжилт нь байгууллагын төсөв, гадаад дотоодын хамтын ажиллагаа, ажиллагсдын дэмжлэг зэрэг олон талт эх үүсвэрт тулгуурлаж байгаа нь хэрэгжилтийн бодит нөхцөл, боломжийг нэмэгдүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь 2 шалгуур 11 бүлгээс бүрдсэн.

№	Шалгуур	Биелэлт хувь	Үнэлгээ
2. ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА			
2.1	Хүний нөөцийн тэргүүлэх чиглэл	80%	Сайн
2.2	Хүний нөөцийн бүрдүүлэлт (одоогийн хүний нөөц)	75%	Дундан
3. БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ			
3.1	Нийт багш ажилчдын нийгмийн баталгаа	65%	Муу
3.2	Нийт багш ажилчдын сургалтад хамруулах хөгжүүлэх	86%	Сайн
3.3	Удирдах албан тушаалтны манлайлах чадварыг хөгжүүлэх	80%	Сайн
3.4	Ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах	80%	Сайн
3.5	Хүний нөөцийн мэдээллийн санг шинэчлэх баяжуулах	95%	Сайн
3.6	Хүний нөөцийн эрсдэлийг удирдлагаар хангах	70%	Дундаж
3.7	Хүний нөөцийг хөгжүүлэх гадаад дотоод байгууллагын хамтын үйл ажиллагааг хөгжүүлэх	65%	Сайн
3.8	Байгууллагын соёлыг хөгжүүлэх	65%	Муу
3.9	Хүний нөөцийн үйл ажиллагааны мэдээллийг ил тод байдлыг бүрдүүлэх	90%	Сайн
Нийт		77.3%	Дундаж

Хүний нөөцийн тэргүүлэх чиглэл нь 80% үнэлсэн нь гадаад харилцаа, хамтын ажиллагаанд тулгуурлан хүний нөөцийн чадавхыг сайжруулах шаардлагатай байна.

Хүний нөөцийн бүрдүүлэлт (одоогийн хүний нөөц) нь 86% үнэлсэн нь хүний нөөцийн хөгжлийн бодлого, хэрэгжүүлэлтийг сайжруулах шаардлагатай байна.

Нийт багш албан хаагчдын нийгмийн баталгаа нь 65% үнэлсэн нь багш, ажилчдыг орон сууцаар хангах болон эрүүл мэндийн асуудлыг шийдсэн бодлогын баримт бичиг боловсруулж төсөвт тусгаж, цалин хөлс урамшууллын системийг зах зээл, эдийн засгийн хөгжилтэй уялдуулан ажиллах ажлын хэрэгжүүлэлт маш муу хангалтгүй байна.

Хүний нөөцийг хөгжүүлэх гадаад дотоод байгууллагын хамтын үйл ажиллагааг хөгжүүлэх шалгуурыг 65% үнэлсэн нь олон улсын байгууллагатай хамтын ажиллагаа хангалтгүй байгаа ба гадаад харилцааны чиглэлээр мэргэшсэн зөвлөх багаар мэргэжил арга зүйн зөвлөгөө авч хамтран ажиллах шаардлагатай.

Байгууллагын соёлыг хөгжүүлэх шалгуур нь 65% үнэлсэн нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэх чиглэлээр хамт олны оролцоо маш муу хангалтгүй байна. Ажилтнуудын хандлага, дадал, чадвар, сонирхлын байдлыг харгалзан сургалт хөгжлийн бодлого боловсруулж, туршлага судлах, мэдээ мэдээлэл солилцох арга хэмжээг тогтмол зохион байгуулж байгууллагын соёлыг бүрдүүлж ажиллах шаардлагатай.

Хэнтий аймгийн Бор-Өндөр суман дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт **77.3%** буюу дундаж (-) байгаа нь **“ДУТАГДАЛТАЙ”** гэж үнэлж байна. Иймд байгууллагын зорилго, үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд нийт багш албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөцийг хөгжүүлэх гадаад дотоод байгууллагын хамтын үйл ажиллагааг өргөжүүлэх, байгууллагын соёлыг хөгжүүлэх, хүний нөөцийн чадавхыг сайжруулахад анхаарах шаардлагатай.

Дүгнэлт гаргасан:

Хүний нөөц, гадаад харилцаа
хариуцсан ажилтан Б.Эрдэнэзул